



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/148

Эмээлтолгой

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1дэх заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бельги улсад үйлдвэрлэсэн sachet нэрийн шоколад, Испани улсад үйлдвэрлэсэн алмонд самар зэрэг бүтээгдэхүүнд афлотоксин хор илэрсэн тул уг бүтээгдэхүүнийг сумын дэлгүүр, худалдааны төвүүдээс хураан авч битүүмжлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Н.Ганжаргал	(4-р багийн Засаг дарга)
Гишүүд	Л.Батцэцэг	(Сумын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга)
	М.Баасанбаяр	(Олон нийтийн цагдаа)
	Б.Буянхишиг	(Хууль эрх зүйн мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга	Б.Лхам-Осор	(Хүнс, Жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн)

2. Сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа дэлгүүр, худалдааны төвүүдээр явж уг бүтээгдэхүүнүүдийг шалган битүүмжилж, ажлын тайланг Засаг даргад танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Н.Ганжаргалд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХЖАРГАЛ

642301039